



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

**Хөрөнгө оруулалтын төлөвлөлт хууль журмын дагуу
хийгдээгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.**

Аудитын код: ДГА-2019/37-ГА

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2019 оны 05 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 70523020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор: П.Энхбаяр
Цахим хаяг: enkhbayar.p@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар -----3
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй -----5
Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа	БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хууль, журмын дагуу үндэслэлтэй хийгдээгүй байна.
Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа	А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.-----6-7
Аудитор П.Энхбаяр	А.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хууль журмын шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.-----7-10
2019 оны 5 дугаар сар	БҮЛЭГ Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас,7052-2734 дугаарын факсаар харилцана уу	Б.1. Эрх шилжүүлсэн зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.-----10-13
ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр	Б.2 Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.-----13-15
	Б.3. Захиалагч, зохиогчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.-----15-17
	Бүлэг 4. Дүгнэлт-----18
	Бүлэг 4. Зөвлөмж-----19
	Холбогдох байгууллагын санал-----20
	Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар-----21



Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
БНБД	Барилгын норм ба дүрэм
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа болон ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТББ	Тендерийн баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТББ	Тендерийн баримт бичиг
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол улс



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын нэр: “Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

Аудитын код: ДГА-2019/37-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх сэдэв батлах тухай 2019 оны А/03 дугаарыг тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт: “Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна уу.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй байна уу.

Аудитын хамрах хүрээ: Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамруулав.

Үндсэн мэдээлэл: Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 06/02 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт батлагдсан бөгөөд уг тогтоолд 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 9/07 тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 12.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 51 ТАХ-нд 7.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан.

Замын-Үүд сумын 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн аудитаар хянагдаж байгаа тул уг аудитад хамраагдаагүй болно.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын судалгаа, үр дүнгийн мэдээллийг боловсрууллаа.



Аудитын хугацаа: Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд ҮАГ-ын батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 07-нд эхлүүлж, аудитын талбарын ажлыг 2019 оны 2 дугаар сарын 25-ноос 3 дугаар сарын 28-ны өдрүүдэд гүйцэтгэж, дэд тайланг баталгаажуулан 2019 оны 5 дугаар сарын 3-нд аймгийн ИТХ, Засаг дарга нарт хүргүүллээ.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорноговь аймгийн Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, аудитын багийн ахлах аудитор Ц.Лүндэгмаа хэрэгжүүлж, аудитор П.Энхбаяр гүйцэтгэв.



Бүлэг А

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хууль, журмын дагуу үндэслэлтэй хийгдээгүй байна.

А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

А.1.1 Батлагдсан зарим ТАХ орон нутгийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй байна.

А.1.1.1 Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 06/02 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэх 11.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ТАХ-нд 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 9/07 тогтоолын нэмэлт өөрчлөлтөөр 0.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

А.1.1.2 Дорноговь аймгийн хэмжээнд 2018 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймаг хөгжүүлэх хэтийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, батлагдсан байх ёстой.

А.1.1.3 Орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд 533.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-ын засвар, тохижилт-50.0 сая төгрөг;
- Хатанбулаг сумын Сулин хээр багийн төвийн барилга-50.0 сая төгрөг;
- Ханги хилийн боомтын Захирагчийн ажлын албаны байр-40.0 сая төгрөг;
- Төрийн албан хаагч, албан тушаалын орон сууц худалдан авах-253.4 сая төгрөг;
- Хүүхдийн ордонд LED дэлгэц авах-62.0 сая төгрөг;
- Саран хөхөө театрын дэлгэц, иж бүрэн дотор гэрэлтүүлэг-78.0 сая төгрөг.

А.1.2 Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө холбогдох байгууллагын санал дүгнэлтийг үндэслээгүй байна.

А.1.2.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр холбогдох байгууллагаас ирүүлсэн ТАХ-ний саналыг хурлаар хэлэлцэж ач холбогдлоор нь эрэмбэлж хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд төлөвлөлтийн талаар судалгаа шинжилгээ хийсэн баримт материал байхгүй байна.



А.1.2.2 Төсвийн хөрөнгөөр хийх засварын ажлыг төлөвлөхдөө барилга байгууламжийн ашиглалт, чанар байдалд мэргэжлийн байгууллагаас журмын¹ дагуу гаргасан дүгнэлт байгаа эсэхийг харгалзаагүй байна. Тухайлбал дараахь засварын ажлуудад мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй байна.

- Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил;
- Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилгын засварын ажил;
- Халзан уул рашаан сувиллын газрын барилгын засвар.

А.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хууль журмын шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

А.2.1 Хөрөнгө оруулалтын жагсаалтад хэрэгжиж дуусах хугацаа тодорхойгүй, төсөвт өртөг зөрүүтэй төсөл арга хэмжээ батлуулсан байна.

А.2.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 12.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 51 ТАХ-нд 7.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төсөв батлагдсан байна. Батлагдсан төсвийн 39.2 хувийг шинээр барих барилга, 12.7 хувийг их засварын ажил, 6 хувийг тоног төхөөрөмж, 1.8 хувийг зураг төсөл, 8.7 хувийг замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажил, 31.5 хувийг 2017 оноос шилжин хэрэгжих ТАХ-нд зарцуулахаар төлөвлөсөн байна.

№	ТАХ-ний төрөл	ТАХ-ний тоо	Мянган төгрөгөөр	
			Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Шинээр барих	16	4,717.7	2,756.9
2	Их засвар	6	947.7	879.5
3	Тоног төхөөрөмж, тавилга	11	277.0	423.3
4	Зураг төсөл	3	98.0	147.8
5	Замын сангийн хөрөнгөөр	5	915.0	615.0
6	2017 оноос шилжих	10	5,362.1	2,218.3
	Дүн	51	12,317.5	7,040.8

А.2.1.2 Хөрөнгө оруулалтын жагсаалтад зарим ТАХ-ний төсөвт өртөгийг удаа дараа өөрчлөн баталсан байна. Үүнд:

- **Сайншанд хот тохижилтын газрын автомашины гражийн барилга:** Жагсаалтад ТАХ-ний хэрэгжих хугацааг 2018 онд эхэлж дуусахаар заасан. Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/02 тогтоолын хавсралтад төсөвт өртгийг 48.0 сая төгрөг, 2018 оны 9/07 тогтоолын нэмэлт өөрчлөлтөөр төсөвт өртгийг 177.0 сая төгрөг, 2018 оны 9/08 тогтоолоор төсөвт өртгийг 128.0 сая төгрөг болгон төсөвт өртгийн дүнг 3 удаа өөрчилж баталсан байна. ТАХ заасан хугацаанд хэрэгжиж дуусаагүй.
- **Сайншанд 4-р багийн эмнэлгийн барилга:** Жагсаалтад ТАХ 2018 онд эхэлж дуусахаар батлагдсан боловч заасан хугацаанд хэрэгжиж дуусаагүй байна.

¹Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 3.4-д “Төсвийн хөрөнгөөр хийх засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэнэ”:



А.2.1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан зарим ТАХ-ний нэрийг өөрчилж хэрэгжүүлсэн байна. Үүнд: Аймгийн ИТХ-ын хурлаар Эрдэнэ суманд Цагдаагийн постын барилга 57.1 сая төгрөгөөр барихаар батлагдсан боловч Замын-Үүд, Эрдэнэ сумдад цагдаагийн постын барилга барих болгон өөрчилж, ХАА зохион байгуулах эрхийг шилжүүлсэн байна.

А.2.1.4 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Төсвийн тухай хууль болон орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу нэр, байршил тодорхой, зураг төсөв боловсруулагдсан, магадлал хийгдсэн, зохих зөвшөөрлүүд олгогдсон ТАХ тусгагдах ёстой. Гэтэл 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэхээр тусгагдсан ихэнх төсөл, арга хэмжээ зураг төсөлгүй батлагдсан байна.

А.2.2 Хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсаны дараа төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулж, баталгаажуулсан байна.

А.2.2.1 Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр төлөвлөсөн ихэнх төсөл арга хэмжээ зураг төсөлгүй батлагдаж, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцад боловсруулсан байна. Тухайлбал:

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг сая төгрөг	Зураг төсөл боловсруулсан огноо
1	Хатанбулаг сум. Сулинхээр багийн төв барилга:	50.0	Зураг төсөлгүй хийгдсэн
2	Цагдаагийн постын барилга, Эрдэнэ сум	57.1	2018.05.18
3	Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилгын засварын ажил	77.7	Зураг төсөлгүй хийгдсэн
4	Халзан уул рашаан сувиллын газрын барилгын засвар	70.0	2018.02.05
5	Сайншанд Хот тохижилтын газрын автомашины гражийн барилга	177.0	2018.08.05
6	Сайншанд сумын 4, 7-р багт дугуйн зам, явган хүний зам барих ажил	180.0	2018.08.03
7	Эмнэлгийн барилга. Сайншанд 4-р баг	1272.0	2018.08.03
8	Иргэдийн хөгжлийн төвийн барилга 1-р баг	400.0	2018.01.16.
9	Иргэдийн хөгжлийн төвийн барилга 2-р баг	400.0	2018.01.16
10	Иргэдийн хөгжлийн төвийн барилга 7-р баг	400.0	2018.03.16
11	Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил I багц:	148.0	2018.01.16

А.2.2.2 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлсэн зарим төсөл арга хэмжээг батлагдсан зураг төсөвгүй хэрэгжүүлжээ. Барилга байгууламжийн төсөв нь батлагдсан зураг төсөлд үндэслэсэн, мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна гэсэн хуулийн заалтыг² мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Хатанбулаг сумын Сулинхээр багийн төв барилга: Барилгын зураг, төсөвгүй баригдсан ба гүйцэтгэгч төсвийн тооцооллыг зохих норм, журмын дагуу боловсруулаагүй байна.

² Барилгын тухай хууль 24 дүгээр зүйл. Барилга байгууламжийн төсөв

24.1-д Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална: 24.1.1-д батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх; 24.2-д Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна



- Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилгын засварын ажил, Аймгийн ЗДТГ-ын барилгын засварын ажлын зураг төслийг аудитын явцад ирүүлээгүй болно.

А.2.2.3 Энэ нь Барилгын тухай хуулийн 40.2-д “Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно” гэж заасныг зөрчиж байна.

А.2.2.4 Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1, 3.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

А.2.3. Барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хуулийн дагуу гаргуулсан байна.

А.2.3.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 5 барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг холбогдох хуулийн³ дагуу авч, барилгын ажлын талбайд тавигдах шаардлагыг⁴ хангасан байна. Үүнд:

- Иргэдийн хөгжлийн төвийн барилга, Сайншанд 1-р баг;
- Иргэдийн хөгжлийн төвийн барилга, Сайншанд 2-р баг;
- Иргэдийн хөгжлийн төвийн барилга, Сайншанд 7-р баг;
- Эмнэлгийн барилга. Сайншанд 4-р баг;
- Сайншанд Хот тохижилтын газрын автомашины гражийн барилга.

А.2.4 Хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй, хөрөнгө оруулалтын бус зардлыг төлөвлөж батлуулсан байна.

А.2.4.1 Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 90.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтуудыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Хилийн цэргийн 0129 дугаар ангид Хилийн харуулын байр /30.0 сая төгрөг/
Хилийн цэргийн 0108 дугаар ангид 3 ширхэг гүний худаг гаргах. /30.0 сая төгрөг/
Хилийн цэргийн 0168 дугаар ангид харуулын байр барих /30.0 сая төгрөг/

А.2.4.2 Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” хэлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй хөрөнгө оруулалтын бус зардлыг төлөвлөж баталсан байна.

- Замын Үүд Эрдэнэ сумдын Цагдаагийн постны тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, гадна камер худалдан авах 10.0 сая төгрөг
- Сайншанд сумын 1.2.7-р багийн ажлын алба болон Өрхийн эмнэлэгт тавилга хэрэгсэл худалдан авах 51.8 сая төгрөг

³ Барилгын тухай хуулийн 37.1.3-д Захиалагч барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх;

⁴ Барилгын тухай хуулийн 16.1-д Захиалагч, гүйцэтгэгч барилга байгууламжийг барихаар олгогдсон газрын хил хязгаар, хэмжээг дүр мэдэн өөрчлөхийг хориглоно. Газрын тухай хуулийн 31.4-д Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.



Бүлэг Б

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Б.1. Эрх шилжүүлсэн зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.

Б.1.1 Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулаагүй байна.

Б.1.1.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар тухай бүр томилон ажиллуулсан байна. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор хуульд⁵ заасан шаардлага хангасан, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн төлөөлөгч, албан тушаалтнуудыг оролцуулсан байна.

Б.1.1.2 Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 362.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээний тендерийг хугацаа алдан зарлаж, ХАА-г журмын дагуу зохион байгуулаагүй байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	Эрх шилжүүлэн авсан албан тушаалтан	Эрх шилжүүлсэн огноо	Тендерийн урилга нийтэлсэн огноо
1	Эрдэнэ сумын ЗДТГ-ын засвар	Эрдэнэ сумын Засаг дарга	2017.12.25	2018.03.05
2	Хатанбулаг сум. Сулинхээр багийн төв барилга	Хатанбулаг сумын Засаг дарга	2018.01.24	2018.04.16
3	Цагдаагийн постын барилга, Эрдэнэ сум	Аймгийн Цагдаагийн газрын дарга	2018.05.18	2018.08.17
4	Сайншанд Хот тохижилтын газрын автомашины гражын барилга	Тохижилт Сайншанд хот тохижилтын газрын дарга	2018.05.16	2018.09.06

Б.1.1.3 Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан зарим ТАХ-ний ХАА-нд хугацаа их зарцуулсан байна. Үүнд:

Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил I багц: Худалдан авах ажиллагаанд 171 хоног зарцуулсан.
Эмнэлгийн барилга. Сайншанд 4-р багц: Худалдан авах ажиллагаанд 270 хоног зарцуулсан

Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил II. III. IV багц: Худалдан авах ажиллагаанд 122 хоног зарцуулсан,

⁵ ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.4-д Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.



Сайншанд Хот тохижилтын газрын автомашины гражын барилга: Худалдан авах ажиллагаанд 86 хоног зарцуулсан: Захиалагч эрхийг хугацаа алдаж шилжүүлсэн, төсөвт өртөг өөрчлөгдсөн, гэрээний хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй болсон

Б.1.1.4 Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолтыг тусгах учиртай.

Б.1.1.5 Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний ХАА-г зохион байгуулах зарим үнэлгээний хороод ТББ-ийг холбогдох хууль журмын дагуу бэлтгэж боловсруулаагүй, гэрээ байгуулах тухай болон үнэлгээний хороо байгуулсан захирамж, хурлын тэмдэглэл, хөрөнгө хүлээн авсан акт зэрэг баримт бичгүүдэд хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг буруу томъёолсон байна. Тухайлбал:

Б.1.1.6 Хатанбулаг сумын Сулинхээр багийн төв барилга, Ханги хилийн боомтын Захирагчийн ажлын албаны байрны засвар зэрэг ТАХ-ний ТББ-д дараах маягтыг аргачлалын дагуу боловсруулж тусгаагүй байна:

- Тендерийн баримт бичигт тендерт оролцогчид өгөх зааварчилгаа;
- тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт;
- тендер шалгаруулалтад ашиглах жишиг маягт бөглөх санамж;
- гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл;
- гэрээ байгуулах гэрээний маягт.

Б.1.1.7 Дээрх үнэлгээний хороод ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.2.2-д⁶ заасны дагуу тендерийг хянан, үнэлгээний дүгнэлт гаргаж захиалагчид хүргүүлж ажиллаагүй байна.

Б.1.3.8 Захиалагч хэрэгцээ шаардлагаа үндэслэл муутай, оновчтой бус тодорхойлсон, тендерт оролцогчид өгөх мэдээлэл тодорхойгүй байгаа нь сонгон шалгаруулалтын явцад өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж байна.

Б.1.3.9 Орон нутгийн өмчийн газар чиг үүргийн дагуу үнэлгээний хороодод тендерийн бичиг баримт боловсруулах, тендер зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн, зөвлөгөө өгч ажиллах шаардлагатай байна.

Б.1.2. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Б.1.2.1 Аймгийн Орон нутгийн өмчийн газар ТБОНӨХБАҮХАТХ-ийн хуульд заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтад тендерийн урилгыг байршуулж нийтэлсэн байна.

Б.1.2.2 Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан босго үнэ *“барааг харьцуулалтын аргаар худалдаж авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 50.0 сая төгрөг, шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг”* гэсэн заалтыг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллаагүй байна.

⁶ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.2.2-д Үнэлгээний хороо тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх



Б.1.2.3 Сайншанд сумын 1, 2, 7 дугаар багуудын ажлын алба болон Өрхийн эмнэлэгт тавилга хэрэгсэл худалдан авах: 51.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний худалдан авах ажиллагааны тендерийг хууль⁷, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэсэн байна.

Б.1.2.4 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй байхад ТАХ-ний ХАА-г зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

Сайншанд сумын 1-р багийн хуучны орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга гадна фасадны засвар: ХАА зохион байгуулан ТОВЭМ ХХК-ийг шалгаруулж 187.9 сая төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгож, засварын ажлыг хүлээн авсан байна. Засварын ажлын нэр, санхүүжилтийг 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулсан байна.

Б.1.2.5 Захиалагч тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулах аргыг сонгохдоо хуульд⁸ заасан шаардлага, чадавх, техникийн тодорхойлолт бусад нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг үнэлдэггүй байна.

Алтанширээ сумын ЗДТГ-т автомашин худалдан авах: Тендерийг харьцуулалтын аргаар 2 удаа зохион байгуулсан боловч амжилтгүй болж шууд гэрээ байгуулсан. ТББ-ын шалгуур хангаагүй ААН шалгаруулсан.

Айраг сумын ЗДТГ-т автомашин худалдан авах: Тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулсан боловч амжилтгүй болж шууд гэрээ байгуулсан. ТББ-д заасан шалгуур хангаагүй, дутуу материал бүрдүүлсэн ААН сонгон шалгаруулсан.

Б.1.3. Худалдан авах ажиллагааны тайланг журмын дагуу боловсруулж, хугацаанд нь тайлагнасан байна.

Б.1.3.1 ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу худалдан авах ажиллагаа явуулсан тухай тайлан бичиж, тендер шалгаруулалтын хавтас хэрэг үүсгэн, баримтын бүрдлийг ханган ажилласан байна.

Б.1.3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдаж, орон нутагт эрх шилжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна.

Б.2. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.

Б.2.1 Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолтын дагуу, гэрээний дагуу гүйцэтгэх үүргээ бүрэн биелүүлэхгүй байна

⁷ТБОНӨХБАҮХАТухай 8.2-д Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ. 8.4-д Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

⁸ ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 34.2-д Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.



А.2.1.1 Гүйцэтгэгч гэрээ, ТББ, зураг төсөвт тусгагдсан ажлыг өөрчлөх, дутуу гүйцэтгэх, барилгын материал эдлэлийг сольж угсрах зөрчил нийтлэг байна. Тухайлбал:

- **Иргэдийн хөгжлийн төвийн барилга, Сайншанд 7-р баг:** Ажлын тоо хэмжээ, зураг төсөвт 450м² зам талбайн тохижилтын ажил хийхээр тусгагдсан байтал 150м² зам талбайн ажлыг гүйцэтгэсэн. Дутуу хийсэн ажлыг дуусгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.
- **Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил I багц:** Гүйцэтгэгч 4 орон сууц засварлахаар гэрээ байгуулсан. Алтанговийн гудамжны 233 байрны /багш нарын 29 айл/ засварын ажлыг дутуу гүйцэтгэсэн, ашиглалтад хүлээн авах комиссын гишүүдээс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж өгөөгүйгээс комиссын актыг баталгаажуулаагүй байна. Гэрээний хэрэгжилтийг дүгнэн, гэрээг цуцлахаар шийдвэрлэж, үлдсэн /111, 109, 107 дугаар байр/ 3 орон сууцны засварын ажлыг зогсоосон байна. Дутуу хийсэн ажлыг дуусган, ашиглалтад хүлээн авах, засвар хийгдээгүй орхигдсон байрны засварын ажлыг гүйцэтгүүлэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

А.2.1.2 Барилгын тухай хуулийн 40.1.17-д “барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

- **Иргэдийн хөгжлийн төвийн барилга, Сайншанд 1-р баг:** ТББ болон зураг төсөвт заасан угсармал хучилтыг цутгамал болгож хийсэн боловч өөрчлөлтийн зураг төсөл боловсруулж баталгаажуулаагүй.

А.2.1.3 Сайншанд Хот тохижилтын газрын автомашины гражийн барилгын ажлын гүйцэтгэгч хууль журмын дагуу Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй байхад барилгын ажлыг эхлүүлсэн байна.

Энэ нь **Барилгын тухай хуулийн** 18.1-д “Барилгын үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхэлнэ”. Дэд бүтцийн сайд, Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын хамтарсан 2003 оны 71/134 дүрээр тушаалаар батлагдсан “Барилга угсралтын ажлыг эхэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журам”-ын 3.3-д “Гүйцэтгэгч нь Барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй объектод ажил гүйцэтгэхийг хориглоно” гэж заасныг зөрчиж байна.

Б.2.2 Гүйцэтгэгч барилгын ажлын явцад захиалагч, зохиогчийн өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.2.2.1 Барилгын ажлын ихэнх гүйцэтгэгч хуульд заасны дагуу барилгын ажлын ил, далд ажлын актыг тухай бүр баталгаажуулан, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.2.2.2 Барилга байгууламж ашиглалт оруулах комисс ЗГ-ын 2017 оны 69 тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн



4.4⁹, 4.7¹⁰ заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна. Комиссын гишүүд үүрэг, даалгавар бүрээр гүйцэтгэсэн ажлын биелэлтийг хянан баталгаажуулаагүй байна.

- **Иргэдийн хөгжлийн төвийн барилга, Сайншанд 1-р баг:** Комиссын гишүүд өгсөн үүрэг даалгаврынхаа биелэлтийг хянаагүй хүлээн авсан.
- **Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил IV багц:** Комиссын гишүүд өгсөн үүрэг даалгаврынхаа биелэлтийг хянаагүй хүлээн авсан.

Б.2.2.3 Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч ГХБХБГ, зураг, төсөв зохиогчид барилгын ажлын явцад хяналт хэрэгжүүлж, үүрэг даалгаврыг тухай бүрд нь өгч, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авсан байна.

Б.2.3 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, магадалшгүй ажлыг хянан баталгаажуулаагүй санхүүжилтийг олгосон байна.

Б.2.3.1 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.12-д “Төсвийн магадалшгүй ажлын зардлыг зөвхөн захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон акт, магадалшгүй ажлын төсөв, гүйцэтгэлийг үндэслэн олгоно” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

- Хатанбулаг сумын Сулинхээр багийн төв барилга: Магадалшгүй ажлын акт үйлдсэн боловч төсөв, гүйцэтгэл байхгүй.
- Ханги хилийн боомтын Захирагчийн ажлын албаны байрны засвар: Магадалшгүй ажлын акт үйлдсэн боловч төсөв, гүйцэтгэл байхгүй.
- Эрдэнэ, Замын-Үүд сумдад баригдсан Цагдаагийн постын барилга: Магадлашгүй ажлын төсөв боловсруулсан боловч захиалагч гүйцэтгэгчийн хамтран тогтоосон магадалшгүй ажлын акт, зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн гэрээ, зураг төсөл боловсруулах гэрээ байхгүй.

Б.2.3.3 Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан ч ашиглалтгүй байгаа дараах арга хэмжээ байна. Үүнд:

Б.2.3.4 Ханги хилийн боомтын Захирагчийн ажлын албаны байрыг сэргээн засварласан бөгөөд Ханги суурьшлын бүсэд бүсийн захирагч, хог хаягдлын мэргэжилтэн 2 ажилладаг бөгөөд ашиглалтын зардал шийдэгдээгүйгээс ашиглалтгүй байна.

Б.3. Захиалагч, зохиогчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Б.3.1 Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

⁹ ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.4-д Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр санал гаргана. Комиссын нийт гишүүдийн саналыг үндэслэн комиссын дүгнэлтийг гаргах бөгөөд уг дүгнэлтийг комиссын нийт гишүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

¹⁰ ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.7-д Комиссын гишүүд үүрэг, даалгавар бүрээр гүйцэтгэсэн ажлын биелэлтэд урьдчилан үнэлэлт, дүгнэлт өгсөн байх бөгөөд комиссын хуралдаанаар үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн хэлэлцэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:



Б.3.1.1 Засгийн газрын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.3-д “Орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Б.3.1.2 Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн дараах төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг дүрмийн дагуу хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Сайншанд Хот тохижилтын газрын автомашины гражийн барилга угсралтын ажил, Хатанбулаг сумын Сулинхээр багийн төв барилга,
- Ханги хилийн боомтын Захирагчийн ажлын албаны байрны засвар,
- Замын-Үүд, Эрдэнэ сумдад барьсан Цагдаагийн постын барилгын ажилд

Б.3.1.3 Эрдэнэ сумын төвд шинээр халаалтын зуух, инженерийн шугам сүлжээ барих, ашиглах, шилжүүлэх ажил: Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг гэрээний дагуу хэрэгжүүлээгүй, улсын комисс хүлээн аваагүй ашиглаж байна.

Б.3.1.4 Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилгын засварын ажил: Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг зураг төсөл зохиогч хэрэгжүүлсэн байна.

Б.3.1.5 Аймгийн ЗДТГ нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 15 ТАХ-ний захиалагчийн хяналтыг ГХБХБГ-аар хэрэгжүүлж, захиалагчийн техник хяналтын зардлын 70 хувь буюу 42.1 сая төгрөгийг гэрээний дагуу олгосон байна.

Б.3.2 Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж баталгаажуулаагүй байна.

Б.3.2.1 Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилгын засварын ажлын зохиогчийн хяналтыг захиалагчийн хяналт гүйцэтгэсэн инженер хэрэгжүүлсэн бөгөөд хяналтыг хэрэгжүүлж баталгаажуулсан тайлан байхгүй байна.

Б.3.2.2 Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын I багцын ажилд Зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч хэрэгжүүлсэн тайлан, өгсөн үүрэг даалгавар байхгүй байна.

Б.3.3 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ журмын заалтыг мөрдөөгүй байна.

Б.3.3.1 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журмын заалтын¹¹ дагуу гүйцэтгэлийг хянан баталгаажуулаагүй байхад санхүүжилтийг олгосон байна.

¹¹Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.3-д Захиалагч төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл арга хэмжээ нэг бүрээр тулган, шалгаж баталгаажуулна



- Сайншанд Хот тохижилтын газрын автомашины гражийн барилгын ажлын гүйцэтгэлийг журмын дагуу тулган шалган баталгаажуулаагүй 42.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил багц: Гүйцэтгэл хянагдаагүй байхад 54.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Эмнэлгийн барилга. Сайншанд 4-р баг: 72.7 сая төгрөгийн гүйцэтгэлийг хянаж баталгаажуулаагүйгээр олгосон.

Б.3.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, эмэгтэйчүүдийн хөгжлийн нэгдсэн төвийн барилгын зураг төсөл боловсруулах ажил: “Дорноговь Их хөгжлийн сан” ТББ /захиалагч/, Гантулга трейд ХХК /гүйцэтгэгч/ нар 2017 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, эмэгтэйчүүдийн хөгжлийн нэгдсэн төвийн барилга” барихаар харилцан тохиролцож гэрээ байгуулжээ.

Захиалагч хуулийн¹² дагуу барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, магадлал хийлгэх холбогдох зардлыг хариуцах чиг үүрэгтэй.

Б.3.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн нэгдсэн төвийн зураг төсөл боловсруулах талаар аймгийн ЗДТГ, Эгэ ХХК-ийн хооронд 21.6 сая төгрөгийн ЗТГ-01/2017 тоот гэрээг 2017 онд байгуулж, зураг төслийг боловсруулан хүлээлгэн өгсөн байна. Тус гэрээнд гадна шугам сүлжээний зураг төсөл болон геологийн зардал багтаагүй байсан тул үнийн дүнг өөрчлөн 36.0 сая төгрөгийн дүнтэй зураг төсөл боловсруулах гэрээг 2018 онд дахин байгуулж, 36.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Б.3.3.4 Багийн дарга нарын мотоцикль 10 ширхэгийг худалдан авахаар Эс Эйч Пи Ложистик ХХК-тай 20.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд, хөрөнгө хүлээн авсан нотлох баримтгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан журмын¹³ заалтыг зөрчиж байна.

Б.3.5 Аймгийн ИТХ-аас хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Б.3.5.1 МУ-ын Сангийн сайдын 2019 оны 6-1/1469 тоот албан бичгээр Дорноговь аймгийн Худалдан авах ажиллагааны 2018 оны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тухай мэдээллийг ирүүлсэн байна. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 90 оноо бүхий шалгуур үзүүлэлтээс 78 оноо авч, “сайн” гэж үнэлэгдсэн байна.

Б.3.5.2 Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 46 дугаар тогтоолоор Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2016-2018 онд хийгдсэн ажлуудын гүйцэтгэл, үр дүнд хөндлөнгийн хяналт шалгалтыг Сайншанд, Замын-Үүд сумдад зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, хяналт шалгалтын удирдамжийг баталсан байна.

¹²Барилгын тухай хуулийн 37.1.3-д Захиалагч барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх; 37.1.10-д барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах

¹³Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан журмын 4.5.10-д Захиалагч хөрөнгө оруулалтын ТАХ-г санхүүжүүлэхдээ Барилга байгууламж их засварын ажлыг хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт, 4.13-д “худалдан авсан тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа батлагдсан маягтын дагуу акт үйлдэж, тамга тэмдэгээр баталгаажуулна”



Шалгалтын дүнг хэлэлцэн үүрэг чиглэлийг аймгийн Засаг даргад хүргүүлэн ажилласан байна.

Б.3.5.3 Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан. Дорноговь аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь улсын болон орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт үнэлэлт дүгнэлт гаргаагүй байна.

Б.3.6 Өмнөх аудитаар өгсөн зарим зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Б.3.6.1 Өмнөх оны аудитаар төсөв батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 6.6.6-д, 4.1.24 дэх заалтуудыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлсэн боловч 2018 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 90.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтуудыг, хөрөнгө оруулалтын бус 61.8 сая төгрөгийн зардлыг тус тус төлөвлөж батлуулсан нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Б.3.6.2 Өмнөх онд гүйцэтгэсэн аудитаар батлагдсан зураг төсөвтэй төсөл арга хэмжээ төлөвлөн батлуулах зөвлөмж өгсөн ч 2018 онд хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан ихэнх төсөл арга хэмжээ зураг төсөлгүй байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гэж үзэхээр байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад хэрэгжиж дуусах хугацаа тодорхойгүй, төсөвт өртөг зөрүүтэй, зураг төсөлгүй төсөл арга хэмжээ батлуулсан байна.
- Хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй, хөрөнгө оруулалтын бус зардлыг төлөвлөж батлуулсан байна.
- Үнэлгээний хороод тендерийн баримт бичгийг журмын дагуу боловсруулж, ХАА зохион байгуулаагүй байна.
- Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
- Худалдан авах ажиллагааны тайланг журмын дагуу боловсруулж тайлагнасан байна.
- Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг ТББ болон гэрээний дагуу бүрэн гүйцэтгээгүй байна.
- Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл, магадалшгүй ажлыг хянан баталгаажуулаагүй санхүүжилтийг олгосон байна.
- Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчил давтагдан гарсан байна

Аудитаар нийт 766.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн, 154.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага бичиж, холбогдох 4 албан тушаалтанд 4 зөвлөмж өгч ажиллаа.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин танаа:

- СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1, 3.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг танаа:

- Засгийн газрын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх.

Орон нутгийн өмчийн газар дарга У.Баярбилэг танаа:

- Үнэлгээний хороодод тендерийн бичиг баримт боловсруулах, тендер зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн, зөвлөгөө өгч ажиллах.

ГХБХБГ-ын дарга Ц.Оюунсайхан танаа:

- Хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу бүрэн гүйцэтгэсэн эсэхийг хянах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ДОРНОГОВЬ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,
Утас/факс: (705) 2-30-03
И-мэйл: domogobi_mgl@yahoo.com

2019.05.09 № 3/877
танай _____-ны № _____-т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагын 2019 оны 1-6/440 тоот албан бичгээр ирүүлсэн Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

1. Аймгийн ЗДТГ-ын барилгын засварын ажлыг Сант номун ХХК-ийн хийсэн зураг төслийн дагуу 2018 оноос эхлэн үе шаттайгаар хийж гүйцэтгэж байна.
2. Сайншанд сумын хуучин орон сууцны барилгуудын засварын 1-р багцаас үлдсэн 111, 109, 107 дугаар байрнуудын засварын ажлыг Зэс-Орд ХХК-иар хийлгэхээр 2019 оны 05-р сарын 02-ны өдрийн ОНТХО-НТШ-20/2019 тоот гэрээ байгуулсан болно.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ
44 8 13915
D:\2019\ZAH-TOOT



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн саналд:

1. Аудитын дүнгийн А.2.2.1-д ирүүлсэн тайлбар, нотлох баримтыг хүлээн авч дүнгийн хэсгээс хасч өөрчлөлт оруулав.
2. Аудитын дүнгийн А.2.1.1-д ирүүлсэн санал нь нэмэлт тайлбар тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Аудитор

П.Энхбаяр

ХЯНАСАН:

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч,

багийн ахлах аудитор

Ц.Лүндэгмаа

2019 он